

МОНГОЛ ХЭЛНИЙ “АХ, ЭГЧ” ГЭДЭГ ХОЁР ҮГИЙН ГАРАЛ, ХУВЬСЛЫН ТУХАЙ


Д.Соронзон (магистр)

Авианы сэлгэц буюу дотоод нугарлын арга нь хэлний задлаг, нийлэг байгуулал үүсэхээс өмнө язгуурлаг хэв шинжтэй байх үед үг бүтээх үндсэн арга байжээ. Чухам энэ үед язгуур хорших, давтах, авиа сэлгэх, үе бүтээвэр нэмэгдэх, хасагдах, жийрэглэх арга нэн бүтээлч байв.

Хэлний хөгжлийн нэн эртний энэ үзэгдлийн ул мөр монгол хэлний язгуур үгийн бүтэц, ялангуяа анхдагч үе бүтээврийн бүтцэд уламжлагдан ирсэн байна. Бид ийм баримтыг төрөл садны нэрсийн гарал үүслийг судлахдаа ажигласан юм. Энэхүү өгүүлэлдээ монгол хэлний “ах”, “эгч” гэдэг үгсийн гарлыг мөшгөж, ажигласан зарим зүйлээ онцлон авч үзье.

Эдүгээ алтай язгуурын хэлнүүдэд дээрх үгсийг тэмдэглэсэн өдий төдий олон үг үүссэн ч тэдгээрээс монгол хэлний “ах” ба “эгч” гэсэн үгстэй хэлбэрийн талаар ойролцоо хэдэн үгийг харьцуулан үзвэл, тэдгээрийн гарал нэгтэй болохыг ажиглан мэдэж болмоор ажээ. Тухайлбал, ах гэдэг үгтэй хэлбэр бүтцийн талаар ойролцоо үгс түрэг хэлнүүдэд дараах байдлаар тохиолдож байна. Үүнд: **аqa** /AT. (:48), Alt. (:8), SY. (:121)/; **аya** /Kaz, Kir. (:8), Tat, Kar, Kum, K.tat, K.kal, Nog, Gag. (:68)/; а:ya /Trkm. (:9)/; **аyay** /Baš. (:8)/ **aqi** /Tuv. (:121)/; **akä** /Öz. (:121)/; **aka** /Uig. (:121)/ гэх мэт. Харин манж-түнгүс хэлнүүдэд: **agu~aka~agu** /Ma./; **a:~aya~a:ya~a:q** /Nan./; **ay~aq** /Ulch./; **ag~aq** /Orok./; **aya~ai** /Ud./; **aka~a:ki~akin** /Oroch./; **aga~aqa~aqa:j~axi:n~akin** /Neg./; **aka:~ake** /Ew./; **axi:** /Sol, Ev./ (:23-24) зэрэг хэлбэртэй тохиолдох ажээ. Харин “эгч” гэдэг үгийг дараах байдлаар тэмдэглэж байна. Үүнд: **ekä** /AT. (:167)/; **ekki** /Chuv. (:467)/; **egeč** /Balk, Khak. (:222, :134)/; **ekeji** /Öz. (:223)/; **ayiča** /Uig. (:3)/; **ege~eke~exe** /Nan, Ulch, Orok, Sol./; **ejke~ejge** /Nan, Ulch, Orok./; **exi(n)~eki(n)** /Ud, Oroch, Neg./; **ekkenu** /Orok./; **okin, okči** /Sol./ (:443) гэх мэтээр хадгалагдан үлджээ.

Хойно дурдах тодорхой үндэслэлд тулгуурлан, хүний цаашилбал хүүхдийн хэлний анхны үгсийг баримжаалж, “ах”, “эгч” гэсэн хоёр үгийн агуулгын харьцааг харьцуулан үзээд, эдгээр үгийн үүсэл гарал нь тодорхой тогтолцоог үүсгэж байгааг ажигласан юм. Уг тогтолцоон дахь хэсгүүд бие биетэйгээ ямагт эсрэгцэж байх бөгөөд тэр нь задрах /эвдрэх?, салах?/ мэт байдлаар хослох шинжээ хадгалсан шинэ шинэ харьцааг үүсгэсээр эцсийн дүнд өнөөгийн бидний хэлэлцдэг “ах”, “эгч” гэсэн хоёр үгийг бий болгосныг үзүүлэх дараах маягийн бүдүүвчийг бэлтгэв.



Орчин үеийн алтай язгуурын хэлтний бүх хэлэнд харилцан адилгүй хэлбэртэйгээр тохиолдож байгаа “ах”, “эгч” гэсэн үгс нь хүний /хүүхдийн/ хэлний шулганасан??? нэгэн үе бүтээврээс улбаатай юм. Тэр нь “me~ma” хэмээх үе бүтээврээс үүдэлтэй бөгөөд хэлний хөгжлийн явцад “meme~mata” /ээж/ зэрэг анхны үгсийг үүсгэжээ¹. Ер хэлэх ба дуудах нь сэтгэлзүйн талаас ихээхэн ялгаатай үйл байсныг анхаарах хэрэгтэй юм.

Хөгжлийн дараагийн шатанд дээрх “me~ma” бүтээвэр хүйс ялган хэрэглэгдэх болов. Ингэснээр тухайн өгүүлэгчид “е” болон “а” авиаг эсрэгцүүлж, өөр бусад төрөл саднаа нэрлэх боломжийг үүсгэжээ. Өөрөөр хэлбэл, энэ үед алтайн язгуур хэлтний сэтгэхүйд эрэгтэй, эмэгтэй хүнийг ялган ойлгох нэгэн дэвшил гарсан бөгөөд тэр нь одоо эр, эмээр эсрэгцэн хэлэгддэг олон үгийг үүсгэсэн байна. Энэ үеийн үг бүтээх үндсэн арга нь үе бүтээврийн эгшиг авиаг сэлгүүлэх явдал байлаа.

Дээр дурдсан эгшиг авиануудаар хүйс ялган хэрэглэж эхэлсэн нь цаашид өөр бусад хүнийг нэрлэх шинэ боломжуудыг үүсгэжээ. Энэ үед алтай язгуурын хэлэнд тухайлбал “ээж”, “аав”, “өвөө”, “эмээ” зэрэг шинэ үгс олноор үүсэж байсныг өнөөгийн төрөл хэлний баримтууд тодорхой харуулж байна. Эндээс ажиглавал зохих гурван зүйл нь нэгдүгээрт, тэр цагийн хүмүүс хүйсээр төдийгүй насаар ялгаатай болохыг ойлгож эхэлсэн. Хоёрдугаарт, ингэж насаар ялгах болсон нь тодорхой шинэ үе бүтээврүүдийг шинээр үүсгэх шаардлагыг бий болгосон. Гуравдугаарт, тэгэж шинэ үе бүтээврийг үүсгэх арга нь илүү боловсорч гийгүүлэгч авиаг сэлгүүлэх явдал болжээ.

Өгүүллийн зорилгодоо нийцүүлэн цаашид задрах бусад хэсгийг үл өгүүлэн эр, эмээр эсрэгцэж байсан “be”, “ba” үе бүтээврийн цаашдын хувьслыг нарийвчлан үзье. Хүний хийсвэрлэн сэтгэх чадвар тасралтгүй нэмэгдэх хэрээр тэдний хэл ч хөгжил хувьслын шинэ үед ирэхэд эгшиг, гийгүүлэгч авианы сэлгэцээр шинэ үе бүтээврүүд

¹ Манж, түрэг хэлнүүдэд ээж, эх гэсэн утгатай “mata” хэмээх үгс олноор хадгалагдан үлдсэн (7-р,) бөгөөд монгол хэлний зарим нутгийн аялгуунд одоо ч эх, эгч хүмүүсээ “маам, маамаа” гэж дуудна. (:325)

үүсдэг арга бүтээлч бус болсон тул эхний гийгүүлэгч авиаг сулруулан гээж өөр хэлбэр үүсгэх нь идэвхтэй болж иржээ. Ингээд дан эгшгээс бүтсэн шинэ үе бүтээврүүд уламжлалт хэлбэртэйгээ эсрэгцэх болсон ч хүйс ялгах өөрийн үүргээ хадгалсаар байсан байна. Харин нөгөө тохиолдолд эсрэг хүйс заасан бүтэц ижил бүтээвэртэйгээ үүрэг төдийгүй, хэлбэрийн талаас ч үл нөхөх харьцаатай болсон байна.

Ийнхүү алтай язгуурын хэлэнд идэвхтэй хэрэглэгдэж байгаад одоо дагаврын шинжтэй болсон “хүн” гэсэн утгатай “ya~ge” үе бүтээврийн тусламжтайгаар “e+ge” /эгэ~эхэ/, “a+ya” /ага~аха/ гэсэн үгс шинээр үүссэн байна. (Орчин үеийн төрөл хэлнүүдийн дээр дурдсан баримтуудтай харьцуулан үзнэ үү.) Харин түүний дараагаар “e” болон “a” язгуураас бусад эр, эм хүйс заасан олон үг үүсжээ. Энэ бол хүйсээр ялгах үзэгдэл хэлзүй-үгийн сангийн төвшинд нэн хүчтэй илэрч байсны тодорхой баримт юм.

Цаашид монгол хэлтний өрх гэрийн зохион байгуулалтай холбоотойгоор “ege~eke” гэсэн үгийн утгад өөрчлөлт гарч, эцэгтэй ханилсан төрсөн эхээс бусад эмэгтэйг нэрлэх үг болжээ. Энэ үйл явц одоогийн “эхнэр” [<eke+ner] гэдэг үгэнд уламжлагдан үлдсэн байна. Гэхдээ үүний зэрэгцээ “эцгийн эм” гэсэн хэлбэр бас байсныг бичгийн дурсгалаас үзэж болно. (:)

Ийм шалтгаанаар урьд нэгэнт үүссэн байсан “ege~eke” хэлбэр дээр мөн “хүн” гэсэн утгатай “ci” бүтээврийг дагуулахад өнөөгийн монгол хэлний “эгч” гэдэг үг үүссэн ажээ.

Харин одоо орчин цагийн монгол зохих хэлний хэлбэрүүдээс өөрөөр бүтэц, утгын хувьсалд орсон төрөл хэлний зарим үгсийн хэдэн онцлогийг товч авч үзье.

Бүтцийн хувьсал:

- Зарим хэлэнд тэргүүн үеийн эгшиг нь уртаар дуудагдах болсноор “a:ya~a:q” хэлбэр үүсэв.
- Зарим хэлэнд тэргүүн үеийн эгшиг “o”-гоор сэлгэж, okin, okci гэх мэт хэлбэрүүд үүсжээ. Монгол бичгийн хэлний “ökin” [<*öki<*öke<*eke “эмэгтэй хүн”] хэмээх үгийн гарал нь үүнтэй ойролцоо байна.
- Зарим хэлэнд тэргүүн бус үеийн эгшгийн сунжран хэлэгдэх болсны дүнд өмнөх гийгүүлэгч нь суларсаар бүрмөсөн сугарахад “a:” гэсэн хэлбэр үүсэв.
- Зарим хэлэнд тэргүүн бус үеийн эгшиг нь хос эгшгийн шинжтэй хэлэгдэх болжээ. Энэ үзэгдэл дундад үеийн монгол хэлэнд үүссэн байсан бөгөөд энэ хэлбэр эдүгээ буриадад ахай, хурьяахай [<kürigen aqai] “хүргэн ах” зэрэг үгэнд хадгалагдан үлдэв.
- Зарим хэлэнд дээрх хос эгшиг нь эцэстээ урт эгшиг болон хувирснаар “axi:” болох буюу гийгүүлэгчээ сугаруулснаар “ai” гэсэн шинэ хэлбэрүүдийг ч үүсгэжээ.
- Олон хэлэнд aqqa, ekki гэх мэтээр урт гийгүүлэгчийн шинжтэй болжээ. Ийм өөр бусад жишээг алтай язгуурын төрөл садны нэрсийн дотроос олныг үзэж болно.

Утгын хувьсал:

- Төрөл хэлнүүдэд “эгч” гэсэн үгийн утга шилжихдээ ээж>авга=нагац эгч> эмээ> >>>>> хойт эх??? гэх мэтээр өөрчлөгддөг нь нийтлэг шинжтэй байна.

- Алтай язгуурын олон хэлэнд “ах” гэсэн үгийн утга шилжиж, авга ба нагац ахыг заадаг болжээ. Эндээс мөшгөж үзвэл, “авга” гэдэг үг үүсэхдээ *abu+aγa “авын талын хүн”, “нагац” гэдэг үг үүсэхдээ *ana[~*ene]+aγa+ɕu “ээжийн талын хүн” гэдэг утгатайгаар холбогдсон байж болох юм.
- Мөн түүнчлэн одоо ч монголын зарим нутагт “насаар эгчмэд” гэхийг “насаар ах” хэмээн хэлэлцдэг нь анх түрүүлж “ахмад” гэсэн утга гарч ирснийг харуулсан эртний баримт байж болох юм???. Дундад үеийн монгол хэлний онцлогийг тусгасан хятад бичгийн зарим дурсгалд /83/ “aqai egeci” /авга эгч/ гэсэн хэлбэр тохиолдож буй нь үүнтэй холбоотой байж мэднэ.

Дүгнэлт

Эдүгээ алтай язгуурын хэлэнд ах, эгч гэсэн үгс үүсэхдээ гарал, хөгжлийн хэд хэдэн чиглэлээр үүссэн байх боловч монгол хэлний ах, эгч гэсэн үгсийн гарал үүслийг тодорхойлох өгүүллийнхээ зорилготой уялдуулан зөвхөн хэлбэр бүтцээр ойролцоо бөгөөд утгын талаас адил үгсийг түүвэрлэн баримт болгон авч үзлээ. Өөрөөр хэлбэл, AT. ара [**para<*baba*], Trkm. eje [**ede<*dede*], Tuv. uwa [**uba<*aba<*baba*], Kir. ece [**ete<*ede<*dede*] гэх мэт хэлбэрүүд нь бидний дээр өгүүлсэнтэй холбоогүй юм.

Дээр дурдсан баримтуудаас үзвэл, өнөөгийн алтай язгуурын хэлтний хэлний ялгаа харьцангуй бага байх үе эсвэл хараахан олон аялгуу болж салаагүй байх тэр цагт 1) ээж 2) аав 3) ах, эгч үгс энэ мэт дарааллаар үүссэн байх магадлал их байна.

Монгол төдийгүй алтай язгуурын хэлнүүдийн төрөл садны нэрсийг харьцуулан үзвэл, хүүхдийн хэлд орох үйл явцтай холбон тайлбарлууштай нэлээд үг байгаа ба тэр нь голдуу ойр дотныхоо хүмүүсийг нэрлэсэн үгс байдаг ажээ.

Товчилсон нэрсийн жагсаалт

/түрэг хэлний бүлэг/

AT. Эртний түрэг хэл
 Az. Азербайжан хэл
 Baš. Башкир хэл
 Kaz. Казак хэл
 Kir. Киргиз хэл
 Tat. Татар хэл
 Trkm. Туркмен хэл
 Uig. Уйгур хэл
 Uz. Өзбек хэл

/манж-түнгүс хэлний бүлэг/

Ev. Эвен хэл
 Ew. Эвенк хэл
 Ma. Манж хэл
 Nan. Нанай хэл
 Neg. Негидаль хэл
 Oroch. Орочи хэл

Orok. Ороки хэл
Sol. Солон хэл
Ud. Удэй хэл
Ulc. Ульча хэл

/монгол хэл, аялгуу/

Cha. Цахар аялгуу
Dag. Дагур хэл
Khor. Хорчин аялгуу
Oir. Ойрд аялгуу
SY. Шар-Уйгур хэл